



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ №10

2018 ОНЫ 6 САР



*"Ийм эрх чөлөө байгаагүй бол
Шекспир, Гётё, Ньютон, Фарадай,
Пастер, Листер нарын хэн ч байхгүй
байсан." А.Эйнштейн*



ОРШИЛ

Их сургууль нь корпорац мөн боловч бизнесийн байгууллагаас боловсролд л байдаг хоёр суурь нөхцлөөр ялгаатай байдаг. Энэ хоёр суурь нөхцөл нь боловсролын тулгуур зарчим бөгөөд академик эрх чөлөө, хамтын удирдлагад оршиж байдаг. Бодлогын зөвлөмжийн энэ дугаарт академик эрх чөлөөний талаар тайлбарлалаа.

Академик эрх чөлөө бол орчин үеийн их сургуулийн нэг чухал зарчим юм. 10-11 зууны үед Ойрх Дорнод, Египет хавиар байгуулагдаж байсан их сургуулиуд эрдэм оюуны өргөн эрх чөлөөтэй байжээ. Гэхдээ үүнийгээ академик эрх чөлөө гэж томъёолоогүй бөгөөд европын колоничиллын үр уршгаар алга болжээ. Харин 19-р зууны эхэн үед Гумбольдын их сургуульд хичээл заах эрх чөлөө, сурах эрх чөлөө гэсэн хоёр тулгуур үзэл баримтлалд тулгуурласан өөрчлөлтийг хэрэгжүүлсэн байна. Харамсалтай нь гуравдугаар рейхийн оргил үед энэхүү академик эрх чөлөөг хаасан байна.

20 зууны эхэн үе хүртэл их сургуулийн багш нарын академик эрх чөлөөг хамгаалах асуудал яригдаж байсангүй. 1901 онд Стэнфордын их сургуулийн профессор Эдвард Росс алтны монополийн эсрэг мөнгийг эргэлтэд оруулах хэрэгтэй, цагаачдыг хязгаарлах, төмөр замын монополийг зогсоох үзэл бодлуудаасаа болж их сургуулийг үндэслэн байгуулагч Стэнфордын гэргий Жейн Стэнфордын дургүйг хүргэснээр

ажлаасаа халагджээ.. Түүнийг хамгаалж хэд хэдэн профессорууд санал бодлоо илэрхийлж улмаар сургуулиа орхисон байна. Энэ үйл явдал америкийн дээд боловсролд хүчтэй цочрол өгсөн бөгөөд Жон Хопкинсийн их сургуулийн философийн профессор Артур Ловжой, Чикагогийн их сургуулийн профессор Жон Дьюи нар 1915 онд Америкийн их сургуулиудын профессоруудын холбоог байгуулж, Гумбольдын үзэл баримтлалд тулгуурлан Зарчмын тунхаглал гэсэн баримт бичгийг баталж гаргажээ. Тэр үед академик эрх чөлөө гэдэг бол цоо шинэ ойлголт байсан юм. 1925 онд Академик эрх чөлөө ба хугацаагүй гэрээ гэсэн мэдэгдэл гаргасан бөгөөд 1940 он хүртэл энэхүү зарчмыг боловсронгуй болгох тал дээр Америкийн коллежуудын холбоотой хамтран ажилласан байна. Энэхүү арав гаруй жилийн ажлын үр дүнд 1940 онд "Академик эрх чөлөө ба хугацаагүй гэрээний зарчмууд" гэсэн мэдэгдлийг боловсруулж баталсан нь академик эрх чөлөөг тайлбарласан хамгийн их нөлөө бүхий баримт бичиг гэж үздэг юм. Өнөөдөр АНУ-ын 250 орчим мэргэжлийн холбоод 1940 оны энэхүү баримт бичгийг хүлээн зөвшөөрсөн байна. 1940 оны мэдэгдэл нь 3 үндсэн эрх чөлөөнд гол анхаарлаа төвлөрүүлсэн бөгөөд түүнийгээ академик эрх чөлөө гэсэн нэрийн дор нэгтгэсэн байна.

1 Багш нар судалгааны ажил хийх, судалгааны ажлынхаа үр дүнг хэвлэн нийтлүүлэх эрх чөлөөгөөр бүрэн хангагдсан байна. Судалгааны ажлын үр дүн,

зардлаа нөхөн төлөх эсэх асуудлыг сургуулийн удирдлагатай урьдчилан харилцан ойлголцсон байх хэрэгтэй. Сургалтын талаар хариуцсан үүрэгт ажлаа бүрэн дүүрэн гүйцэтгэх ёстой.

2 Багш нар анги танхимд өөрийн заадаг хичээлийн сэдвийг хэлэлцэхэд эрх чөлөөтэй байна. Гэхдээ өөрийн хичээлтэй холбогдолгүй, маргаантай санал зөрөлдөөнтэй асуудлыг хэлэлцэхгүй байх талаар

болгоомжтой байх хэрэгтэй. Шашны үзэл бодлоос болон их сургуулийн бусад зорилго, бодлогоос болж академик эрх чөлөөг зарим нэг талаар хязгаарлах бол багшийг ажилд авахдаа бичгээр тодорхой мэдэгдэх хэрэгтэй.





Эдвард Альсворт Росс



“Хэлэх үгээ хянаж бай! Профессор аа!”
Стэнфордын их сургуулийн сонинд гарсан шог зураг.





3

Их, дээд сургуулийн багш хүн иргэнийхээ хувьд бичих, үг хэлэхдээ сургалтын байгууллагын хяналт, цензурээс хамааралгүй байх учиртай. Гэхдээ нийгэмдээ эзэлж байгаа байр суурь нь тэдэнд ямар нэг үүрэг хариуцлага ногдуулж болно. Мөн боловсролын байгууллагын багш, эрдэмтний хувьд түүний

хэлсэн үгийг олон нийт мэргэжил, ажилладаг сургуультай холбож ойлгох, тайлбарлаж болохыг бас санаж байх ёстой. Тиймээс үргэлж анхаарал болгоомжтой байж, хэлж байгаа үг, бичиж байгаа санаагаа байнга хянаж, бусдын санаа бодлыг хүндэтгэж, их сургуулийн нэрийн өмнөөс яриагүй гэдгээ байнга хэлж байх ёстой.

1951 онд Канадын их сургуулийн багш нарын холбоо байгуулагдсан байна. 1959 онд одоогийн Виннипегийн их сургуулийн профессор Харри Кроуыг их сургуулиа шүүмжилсэн захидал бичсэнийх нь төлөө ажлаас нь халсан байна. Үүний дараа Канадын их сургуулийн багш нарын холбоо академик эрх чөлөөг хамгаалах талаар шийдвэртэй алхмуудыг хийжээ. Өнөөдөр их сургуулиудын профессор багш нарын холбоо их сургуультайгаа академик эрх чөлөөний талаар Канадын их сургуулийн багш нарын холбооноос гаргасан зөвлөмжийг хамтын гэрээндээ тусгасан байна.

1993 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага чуулган дээд сургуулийн багшийн статусын талаар олон улсын хэмжээнд стандарт тогтоох зорилгоор зөвлөмж боловсруулж, батлах шийдвэр гаргажээ. Академик эрх чөлөөний талаар бусдаас тэргүүлж явсан Америкийн Нэгдсэн улс тэр үед ЮНЕСКО-оос гарсан байсан тул ЮНЕСКО-гоос Канад улсад хандаж, Канадын их сургуулийн багш нарын холбооны гүйцэтгэх захирал Доналд Саважийг экспертээр авч ажиллуулж, 1997 онд

“Дээд сургуулийн багшлах боловсон хүчний статусын талаарх зөвлөмжийг” баталсан байна. ЮНЕСКО энэхүү зөвлөмждөө академик эрх чөлөөг хязгаарлахад хүргэж болох улс төрийн дарамт нь багшлах хамт олныг эмзэг байдалд оруулж байгаад сэтгэл зовниж байгаагаа илэрхийлж, боловсрол эзэмших эрх, сургах, судалгаа хийх эрхийг зөвхөн академик эрх чөлөөг эрхэмлэсэн, дээд боловсролын байгууллагын бие даасан байдлыг хангасан нөхцөлд бүрэн хангахыг мэдэгдэж байгаагаа илэрхийлжээ.

2011 онд Канадын их сургуулиудын 100 жилийн ойгоор академик эрх чөлөөний талаар шинэ мэдэгдлийг гаргасан байна. Академик эрх чөлөөний талаарх энэхүү шинэ мэдэгдэл нь академик эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөө хоёрыг салгаж, академик эрх чөлөө бол их сургуулийнхаа нэгдлийг хангах, их сургуулийн бие даасан байдал, дотоод стандартад тулгуурлах ёстой гэжээ. Харин энэ шинэ мэдэгдэл нь Канадын их сургуулийн багш нарын холбооны зүгээс хүчтэй шүүмжлэлд өртсөн байна.

АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨНИЙ 4 ТУЛГУУР

Академик эрх чөлөө бол 2 үндсэн, 2 туслах элементээс тогтдог. Хамгийн гол үндсэн эрх чөлөө бол хичээл заах эрх чөлөө юм. Хичээл заах эрх чөлөө гэж чухам юуг хэлж байна вэ? Үүнд, юу заахаа тодорхойлох эрх чөлөө өөрөөр хэлбэл хичээлийн агуулгыг тодорхойлох, яаж заахаа тодорхойлох буюу заах арга зүйгээ сонгох, хэн энэ хичээлийг заах эрх чөлөө, өөрөөр хэлбэл ил тод сонгон шалгаруулалтын үр

дүнд багшийг сонгох, хэнд энэ хичээлийг заахаа тодорхойлох, өөрөөр хэлбэл, энэ хичээлийг үзэхийн тулд тавих шаардлага стандартыг тодорхойлох, оюутны мэдлэг эзэмших үйл явцыг хэрхэн дүгнэхийг тодорхойлох, өөрөөр хэлбэл шалгалтын ямар арга хэрэглэх, тухайн оюутныг цаашид дэвшүүлэх эсэхийг тодорхойлох, өөрөөр хэлбэл, эцсийн дүн тавих, үнэлгээ өгөх гэсэн зүйлүүд багтана. Судалгааны ажил эрхлэх эрх





чөлөө гэдэгт юуг судлахаа тодорхойлох эрх чөлөө, судалгааны арга барилаа сонгох эрх чөлөө, судалгааны зорилгоо тодорхойлох эрх чөлөө, судалгааныхаа үр дүнг олон нийтэд хүргэх арга хэлбэрээ сонгох, тухайлбал, хэвлэлд нийтлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, олон улсад хэлэлцүүлэх гэх мэт эрх чөлөө багтана. Эдгээр хоёр үндсэн эрх чөлөө нь дараах хоёр туслах элементээр дэмжигдэж байдаг. Үүнд, өөрийн удирдлага ба хугацаагүй гэрээ орно. Их сургуулийн үйл ажиллагаатай холбоотой санаа бодлоо илэрхийлэх эрх чөлөө, их сургуулийн хэмжээнд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, их сургуулийн удирдлагын орон тоонд хүмүүсийг сонгон

шалгаруулж томилох, эсвэл албан тушаалаас нь огцруулахад оролцох эрх чөлөө нь өөрийн удирдлагын илрэл юм. Хугацаагүй гэрээ гэдэг бол академик эрх чөлөөний баталгаа болж байдаг бөгөөд багшийн ажилд орсны дараах туршилтын хугацаагаа амжилттай дүүргэсний дараа болон сургалт, судалгааныхаа ажлын үр дүнг эрдмийн хамт олноороо урьдчилсан дүрэм зааврын дагуу үнэлүүлж дүгнүүлсний эцэст их сургуульдаа баталгаатай ажлын байртай байх эрхийг хэлнэ. Профессор багшид тавигдах доод хэмжээний шаардлагыг хангаж чадаагүй, мэргэжлийн ёс зүйн стандартыг зөрчсөн багшийн хугацаагүй гэрээг цуцлах боломжтой байдаг.

ХУГАЦААГҮЙ ГЭРЭЭ

Их сургуульд багшийн ажилд шинээр орж байгаа хүн туршилтын хугацаа дууссаны дараа хугацаагүй гэрээ авах эрхтэй байдаг. Хугацаагүй гэрээг тэтгэвэрт гарахаас гадна

ёс зүйн алдаа гаргасан, эсвэл их сургууль санхүүгийн хямралд орсон зэрэг онцгой нөхцөл байдалд цуцалж болно. Хугацаагүй гэрээг хэрэглэх ерөнхий зарчмуудыг энд тайлбарлая.

1 Багшийн ажилд томилох шаардлага, нөхцөл нь томилолт эхлэхийн өмнө

бичгээр үйлдэгдэж их сургууль, багш хоёрт хадгалагдах ёстой.

2 Жинхэнэ багш болон дээд түвшний албан тушаалд томилохын өмнөх туршилтын хугацаа 7-оос дээшгүй байх ёстой. Энэ хугацаанд багш өөр сургуульд шилжиж очвол өмнөх сургуульд ажилласан

туршилтын хугацааг тооцож, үлдсэн хугацаанд туршилтын журмаар ажиллуулна. Хэрэв багшийн ажил хангалтгүй учраас цаашид үргэлжлүүлэн ажиллуулахгүйгээр шийдсэн бол 1 жилийн өмнө энэ тухайгаа мэдэгдэх ёстой.

3 Туршилтын хугацаанд багш академик эрх

чөлөөг бусад профессор багшийн нэг адил эдэлнэ.

4 Багшийн хугацаагүй гэрээг цуцлах асуудлыг багш нарын зөвлөл, их сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж эцсийн шийдвэрийг гаргана. Тухайн багш өөрийн асуудлыг хэлэлцэхэд оролцож сонсох, тэр байтугай зөвлөх

хүнтэйгээ хамт байлцах эрхтэй. Ёс зүйн алдаа гаргаагүй хугацаагүй гэрээтэй багшийн хувьд гэрээг өөр шалтгаанаар цуцлах бол 1 жилийн цалинтай тэнцэх нөхөн олговор авах эрхтэй.





5


Санхүүгийн хямралаас болж хугацаагүй гэрээг цуцалж байгаа бол үүнийг олон

нийтэд ил тод мэдэгдэх ёстой.

Хугацаагүй гэрээг дэлхийн бусад улс оронд хэрэглэдэг. Их Британид хугацаагүй гэрээний систем хэрэглэж байсныг Тетчерийн засгийн газар болиулж, түүний оронд байнгын болон түр гэрээг багш, судлаачдын аль алинд бий болгосон байна. Герман улсад их дээд сургуулийн багш нарыг хоёр ангилж үздэг. Нэг талаас (C2/W2) зэрэглэлийн профессор бол төрийн албан хаагч бөгөөд насан туршдаа ажиллах эрхээр хангагдсан байдаг. Энэ албан тушаалд томилогдох нэг шалгуур бол хоёрдахь докторын зэрэг (habilitation) хамгаалах ёстой. Иймээс Германд хугацаагүй гэрээг харьцангуй ахмад насандаа олж авдаг. Германы профессоруудын

дундаж нас нь 42 гэсэн тооцоо бий. 2010 оны байдлаар их дээд сургуулийн нийт багшийн 9% -нь профессор, 66%-нь залуу багш нар болон докторын зэрэг горилогч оюутан багш нар эзэлж байна. Харин 25%-нь бусад ажилтнууд байна. Австралид их дээд сургуульд 5 зэрэглэлийн багшийн орон тоо байдаг. Үүнд, туслах багш, багш, ахлах багш, дэд профессор, профессор гэсэн эрдмийн зэрэглэлтэй. Профессор болохын тулд хүлээн зөвшөөрөгдсөн, манлайлах чадвартай, нэр төртэй байх гэсэн шалгууруудыг хангах ёстой. Харин хугацаагүй гэрээг Австралийн их дээд сургуульд хэрэглэдэггүй.

ОУЛУ-ИЙН ИХ СУРГУУЛИЙН БАГШИЙН АЛБАН ТУШААЛ, ТАВИХ ШААРДЛАГА





ACADEMIC FREEDOM

БАРИМТ 1

Европын холбооны ихэнх улс орнуудад Академик эрх чөлөө, үг хэлэх эрх үндсэн хуулиар хамгаалагдсан байдаг. АНУ-д аливаа эрх чөлөөг хуулиар хамгаалсан байдаг бөгөөд академик эрх чөлөө бол эрдмийн хамт олны эрх мэдлийн асуудал байдаг. Энэ эрх мэдэл нь их сургуулиас профессор багш нартаа олгож байгаа тэднийг ажил үүргээ гүйцэтгэх, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлснээс болоод ажлаас халахаас хамгаалсан эрх бөгөөд харин хуулийн шийтгэлээс хамгаалахгүй. Их Британи

улсад академик эрх чөлөөг хамгаалах талаар үндсэн хуульд онцгойлон бичигдээгүй боловч "бичигдээгүй үндсэн хууль" үйлчилж байдаг. Европын холбооны 27 улсад үг хэлэх эрхийг үндсэн хуульдаа тусгасан байна. 20 оронд академик эрх чөлөөг ямар нэг хэмжээгээр үндсэн хуульдаа хамгаалсан байна. Тухайлбал, Испани улсын Үндсэн хуулийн 20-р зүйлд "Дараах эрхийг хүлээн зөвшөөрч хамгаална. ...с) академик эрх чөлөөтэй байх эрх" гэжээ.





Европын холбооны улс орнуудад Академик эрх чөлөө, үг хэлэх эрх үндсэн хуулиар хамгаалагдсан байдал

Улс	Үг хэлэх эрх	Академик эрх чөлөө	Улс	Үг хэлэх эрх	Академик эрх чөлөө
 Австри		Судалгаа, хичээл заах эрх чөлөө	 Итали		Судалгаа, хичээл заах эрх чөлөө
 Бельги		Хичээл заах	 Латви		Хамгаалалтгүй
 Болгар		Судалгаа, их сургуулийн бие даасан байдал	 Литва		Судалгаа, хичээл заах эрх чөлөө, их сургуулийн бие даасан байдал
 Хорват		Судалгаа, их сургуулийн бие даасан байдал	 Люксембург		Академик эрх чөлөөг зориуд тэмдэглэсэн
 Кипр		Судалгаа, их сургуулийн бие даасан байдал	 Мальт		Хамгаалалтгүй
 Чех		Хамгаалалтгүй	 Голланд		Хамгаалалтгүй
 Дани		Судалгаа, урлагийн бүтээл	 Польш		Судалгаа, хичээл заах эрх чөлөө
 Эстони		Хамгаалалтгүй	 Португал		Хичээл заах эрх чөлөө
 Финланд		Судалгаа, хичээл заах эрх чөлөө, их сургуулийн бие даасан байдал	 Румын		Их сургуулийн бие даасан байдал
 Франц		Хамгаалалтгүй	 Словак		Судалгаа, хичээл заах эрх чөлөө
 Герман		Судалгаа, хичээл заах эрх чөлөө	 Словени		Судалгаа, их сургуулийн бие даасан байдал
 Грек		Судалгаа, хичээл заах эрх чөлөө, хугацаагүй гэрээ	 Испани		Академик эрх чөлөөг зориуд тэмдэглэсэн
 Унгар		Судалгаа, хичээл заах эрх чөлөө	 Швед		Судалгааны эрх чөлөө
 Ирланд		Хамгаалалтгүй	 Их Британи		Хамгаалалтгүй

БАРИМТ 2 - ПРОФЕССОР СТЕЙНЕР АЛЯСКИЙН ИХ СУРГУУЛЬ ДАХЬ АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААР ЗАРГАЛДСАН НЬ

2008 онд АНУ-ын Засгийн газраас Аляскийн Бристолэргийн хавиар газрын тосны олборлолтыг өргөжүүлэх санал тавьсан байна. Профессор Стейнер энэ төслийн байгальд орчинд үзүүлэх эрсдэл, ялангуяа газрын тос асгарахаас нутгийн ард түмэн санаа зовниж байгаагаа хөндөж тавьжээ. Газрын тос олборлолтын компанийн

удирдлагууд их сургуулийн удирдлагуудтай уулзаж хэрэв профессор Стейнер өөрийн эсэргүүцлээ цаашид үргэлжлүүлбэл компани их сургуульд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ зогсоохоо мэдэгджээ. Их сургуулийн академик эрх чөлөөг хангах бодлогын үүднээс профессор Стейнерийн олон түмэнд хийж байгаа энэхүү





мэдэгдэл нь эрх зүйн хувьд хамгаалагдсан байна. Гэвч Далай болон агаар мандлын үндэсний агентлагаас профессор Стейнерийн авч байсан судалгааны төслийн санхүүжилтийг хаахаар их сургууль болон Далай болон агаар мандлын үндэсний агентлагаас хамтран шийдвэрлэсэн байна. Энэ бол байгаль орчны талаар санаа зовж байгаагаа илэрхийлсэн профессорын судалгааны ажлын санхүүжилтийг зогсоосон анхны жишээ байжээ. 2009 онд профессор Стейнер их сургуульдаа гомдол гаргасан боловч их сургууль нь авч хэлэлцээгүй байна. 2010 оны 2-р сард профессор Стейнер ажлаасаа гарчээ.

Энэ явдал Мексикийн буланд Бритиш Петролиум компани 11 сая баррел газрын тос асгаж далайн буланг маш ихээр бохирдуулахаас 2 сарын өмнө болжээ. Харамсалтай нь Обамагийн Засгийн газраас гаргасан газрын тосны үйл ажиллагааг цаашид өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлсэн учраас энэ гомдлыг цаашид авч хэлэлцээгүй байна. Харин америкийн хэвлэл мэдээллийн байгууллагууд эрдэм шинжилгээний ажилтны холбооноос дахин ийм зүйл гаргахгүйн тулд эрх зүйн үндсийг бүрдүүлэх тал дээр эрчимтэй ажиллаж эхэлсэн байна.

БАРИМТ 3 - УИЛЛИЯМ РОБИНСОНЫ ЖИШЭЭ

Калифорний их сургуулийн социологийн профессор Уиллиям Робинсон Газын зурваст Палестины эсрэг Израилын явуулж байгаа халдлагыг шүүмжилсэн мэдээллийг өөрийн хичээл заадаг бакалаврын оюутнуудад и-мэйлээр явуулсан байна. Хэдийгээр тэр өөрөө еврей хүн боловч Газын зурваст Израилын явуулж байгаа дайныг нацистуудын дайнтай ижил гэж хурцаар шүүмжилдэг байна. Тэрээр и-мэйлдээ зурагнууд хавсарган явуулжээ. Түүний хэд хэдэн оюутнууд тэрхүү и-мэйлийг Еврейчүүдийн байгууллагад дамжуулсан байна. Еврейчүүдийн холбооноос

их сургуульд эсэргүүцэл илэрхийлсэн байна. Багш нарын зөвлөл уг асуудлыг хэлэлцэхэд нэг хэсэг профессорууд академик эрх чөлөөг хамгаалах ёстой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь профессор Робинсон өөрийн албан тушаалаа урвуулан ашиглаж, семитизмийн эсрэг уучилж болшгүй хөдөлгөөнд орсон гэж үзэж байжээ. Хэдэн сарын дараа гурван тусдаа ажилласан комиссоос энэ асуудлыг цаашид үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй гэж үзсэн байна. Их сургуулийн удирдлага ч энэ саналыг дэмжиж, албан ёсны шалгалтыг зогсоосон байна.

БАРИМТ 4 - ПРОФЕССОР ВАРД ЧЕРЧИЛЛИЙН ЖИШЭЭ

Колородагийн их сургуулийн үндэсний цөөнхийн асуудал судлаач профессор Вард Черчилл 9 сарын 11-ны үйл явдалтай холбогдуулан террористуудыг “өөрийн итгэлдээ зоригтой хандсан” гэж магтахын сацуу Дэлхийн худалдааны төвд хохирогчдыг “өчүүхэн эйхманнууд” гэж нэрлээд веб сайтанд байрлуулсан байна. Судалгааны ажилдаа том алдаа гаргасан тул түүнийг их сургуулиас хөөсөн байна. Профессор Черчилл үндэслэлгүй халагдсан учраас хохирсон гэсэн үндэслэлээр

шүүхэд хандсан бөгөөд шүүх түүний гомдлыг хүлээн авч, хохирлыг 1 доллар гэж үзсэн байна. Түүний дараа профессор Вард судалгааны ажилдаа “өчүүхэн эйхманнууд” гэсэн нэр томьёо оруулснаас болж халагдсан учир академик эрх чөлөөг хамгаалах үүднээс их сургуульд эргүүлэн ажилд нь буцааж ажиллуулах ёстой гэсэн үндэслэлээр шүүхэд хандсан байна. 2009 оны зун шүүхээс их сургуулийн шийдвэрийг баталж, профессорын гаргасан гомдлыг хүлээж авах үндэсгүй гэж үзжээ.





МАНАЙ ОРНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨГ ӨРГӨТГӨХ ТАЛААР САНАЛ ЗӨВЛӨМЖ

- 1 Дээд боловсролын хуульд академик эрх чөлөөний талаар тусгагдаагүй байгаа учраас энэ асуудлыг хуулийн өөрчлөлтөөр тусгаж өгөх хэрэгтэй байна.
- 2 Академик эрх чөлөөний талаарх ойлголтыг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх бүх түвшинд тодорхой болгох шаардлагатай байна.
- 3 Их, дээд сургуулиуд профессор багштай байгуулж байгаа хөдөлмөрийн гэрээнд академик эрх чөлөөний талаар тусгадаг байвал зохино.
- 4 Профессорбагшнаракадемикэрхчөлөөний талаар их дээд сургуулиас тавьж байгаа бодлогыг хүндэтгэн үзэж мөрдөж байвал зохино.
- 5 Хугацаагүй гэрээний талаар багшийн хөдөлмөрийн гэрээнд тусгах нь зөв гэж үзэж байна. Гэхдээ профессор багшид тавих шаардлагыг бүрэн хангасан хүнд энэ боломжийг олгодог байх тусгай журам хэрэгтэй.
- 6 Багшлах ажлын туршилтын хугацааг 5-7 жилээр тогтоож, улс даяар хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу.





ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

American Association of University Professors. 1940 Statement of Principles on Academic Freedom and Tenure.

Jerry G. Gaff. Freedom for a New Age. Association of American Colleges and Universities. 2015

Academic Freedom in the U.K.: Legal and Normative Protection in a Comparative Context. University and College Union. 2017

Academic Freedom and Its Protection in the Law of European States. European journal of comparative law and governance 3 (2016) 254-345.

UNESCO's Recommendation concerning the Status of Higher-Education Teaching Personnel of 1997

Hamilton, N.H. 2009. "Proactively Justifying the Academic Profession's Social Contract." In The Future of the Professoriate: Academic Freedom, Peer Review, and Shared Governance. Washington, DC: Association of American Colleges and Universities, 1-18.

Tiede, H.G. 2015. "The 1940 Statement of Principles on Academic Freedom and Tenure: Its History and Continued Relevance." Paper presented at the annual meeting of the Association of American Colleges and Universities, January 2015.

SUMMARY

Although a university is a corporation, it differs from a business because of two conditions that are unique to education and that have come to be considerable fundamental: academic freedom and shared governance. In this issue of the policy briefs we focused on academic freedom. Key document for academic freedom is 1940 Statement of Principles on Academic Freedom and Tenure produced by the American association of University Professors. The propose of this statement is to promote public understanding and support of academic freedom and tenure and agreement upon procedures to ensure them in colleges and universities. Academic freedom is essential to these purposes and applies to both teaching and research. Freedom in research is

fundamental to the advancement of truth. Academic freedom in its teaching aspect is fundamental for the protection of the rights of the teacher in teaching and of the student to freedom in learning. Tenure is a means to certain ends; specifically: (1) freedom of teaching and research and of extramural activities, and (2) a sufficient degree of economic security to make the profession attractive to men and women of ability. Freedom and economic security, hence, tenure, are indispensable to the success of an institution in fulfilling its obligations to its students and to society. This is a relatively new concept for the Mongolian higher education. Thus, the Policy brief provides a set of policy recommendations.



ШУТИС-ийн олон улсын дээд боловсрол судлалын төв

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

Хэвлэлд бэлтгэсэн: Ч.Болорчимэг

© ШУТИС Хэвлэлийн газар

